



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/836

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2 дахь хэсгийн 2.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагдаагийн газрын “Удирдлагын манлайлал тэргүүн туршлага” болзолт уралдаанд алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах орчныг сайжруулах зардалд дэмжлэг болгон 1 500 000 төгрөг /Нэг сая таван зуун мянга/-ийг баталж зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 1 500 000 төгрөг /Нэг сая таван зуун мянга/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ